



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 474

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 3,844,490.00 (гурван сая найман зуун дөчин дөрвөн мянга дөрвөн зуун ерэн) төгрөгийн балансын үнэ, 808,873.28 (найман зуун найман мянга найман зуун далан гурван төгрөг хорин найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Мэдээллийн Монцамэ агентлагт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Мэдээллийн Монцамэ агентлагийн дарга Б.Ганчимэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



00000001



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрыг
2019 оны 11 дүгээр сарын 19 ний өдрийн
474 дугаар тогтоолын хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
МЭДЭЭЛЛИЙН МОНЦАМЭ АГЕНТЛАГТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Компьютер (dell optiplex 7060)	2018.12.27	ш	1	2,974,730.00	627,115.72	2,347,614.28
2	Принтер (canon lbr 6030)	2018.12.27	ш	1	285,000.00	60,081.56	224,918.44
3	Програм (вирусны)	2018.12.27	ш	1	584,760.00	121,676.00	463,084.00
	Нийт дүн				3,844,490.00 (гурван сая найман зуун дөчин дөрвөн мянга дөрвөн зуун ерэн)	808,873.28 (найман зуун найман мянга найман зуун далан гурван төгрөг хорин найман мөнгө)	3,035,616.72 (гурван сая гучин таван мянга зургаан зуун арван зургаан төгрөг далан хоёр мөнгө)